

**ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАГДСАН ИНД-105-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ**

<p><b>Шүхрийн үйл ажиллагааны дүрэм.</b> (Шинэчлэгдэж байгаа) /12 хуудас/ 2016 оны NZ amend.6</p>	<p><b>ШҮХРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b> (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) / 7 хуудас (үндсэн дүрэм-21 хуудастай байсан)/ 1997 оны NZ original</p>	<p align="center"><b>Тайлбар</b></p>
<p><b>А Бүлэг-Ерөнхий зүйл</b></p>	<p><b>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b></p>	
<p><b>105.1. Хамрах хүрээ</b> Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно: (1) дараахаас бусад шүхрийн үйл ажиллагааны: (i) <a href="#">ослын шүхрийн буулт</a>; (ii) <a href="#">агаарын хөлгөөс үйлдээгүй шүхрийн буулт</a>; (2) шүхрийн төхөөрөмжийн; (3) шүхрийн техник үйлчилгээний.</p>	<p><b>105.1. Зорилго</b> (a) Энэ дүрмийн зорилго нь агаарын хөлгөөс шүхрээр буух үйл ажиллагаа болон шүхрийн тоноглол, шүхэрт хийгдэх техник үйлчилгээнд тавигдах шаардлагыг тогтооход оршино.</p>	<p>Хамрах хүрээ болгож, (1) (i) (ii) заалтууд нэмэгдэн дэлгэрэнгүй зааж өгсөн.</p>
<p><b>105.3. Нэр томьёо ба товчлол</b> Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.</p>	<p><b>105.3. Тодорхойлолт ба товчлолууд</b></p>	<p>Нэр томьёоны тайлбар ИНД-1-д орсон.</p>
<p><b>105.5. Шүхрийн <a href="#">буулт үйлдэх этгээд</a></b> (a) Энэ зүйлийн (b) болон (c)-д зааснаас бусад тохиолдолд, шүхрийн буулт үйлдэх этгээд нь дараах үүрэгтэй: (1) шүхэрчний үнэмлэх эзэмшдэг байх; (2) тухайн үнэмлэх болон зэрэглэлийн эрх, хязгаарлалтыг мөрдөх; (3) шүхрийн байгууллагын Ерөнхий зааварт багтсан үйл ажиллагааны стандарт болон журмыг мөрдөх. (b) Хэрэв сурагч-шүхэрчин нь шүхрийн байгууллагаас олгосон Сургагчийн зэрэглэл эзэмшдэг Сургагчийн хяналтад байгаа бол, энэ зүйлийн (a)-г мөрдөхийг шаардахгүй. (c) Хэрэв тандем зорчигч нь дараах <a href="#">тандем-мастерын</a> хяналтад байгаа бол, энэ зүйлийн (a)-г мөрдөхийг шаардахгүй: (1) шүхрийн байгууллагаас олгосон тандем-мастерын зэрэглэл эзэмшдэг; (2) 18 нас хүрсэн; (3) ИНД-67-гийн дагуу <a href="#">Даргын олгосон</a> 2-р ангиллын <a href="#">хүчинтэй</a> эрүүл мэндийн гэрчилгээ эзэмшдэг.</p>	<p><b>105.5. Шүхэрчний <a href="#">эрх, үүрэг</a></b> (a) Шүхэрчин нь дараах эрх, үүрэгтэй:  1/ эзэмшиж байгаа гэрчилгээ ба зэрэглэлд заасан эрх, хязгаарлалтын хүрээнд шүхрийн үйл ажиллагаанд оролцох; 2/ шүхрийн үйл ажиллагаанд нь оролцож байгаа эрх бүхий байгууллагынхаа Үйл ажиллагааны зааварт тусгагдсан журам, стандартыг дагаж мөрдөх.  (б) Хүчин төгөлдөр гэрчилгээ эзэмшигчийн хяналтанд шүхрийн үйл ажиллагаанд оролцож байгаа сурагч шүхэрчинд энэ зүйлийн (a)-д заасан шаардлага хамаарахгүй.  (в) Дараах шаардлагыг хангасан цувааны ахлагчийн шууд удирдлага, хяналтан доор шүхрээр буух цувааны шүхэрчинд энэ зүйлийн (a)-д заасан шаардлага хамаарахгүй: 1/ эрх бүхий байгууллагаас олгосон <a href="#">цувааны ахлагчийн</a> зэрэглэлтэй; 2/ 18 нас хүрсэн; 3/ ИНД-67-гийн дагуу, эрүүл мэндийн 2-р ангиллын гэрчилгээ эзэмшсэн байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан.</p>

<p><b>105.7. Аюултай нөхцөл байдал үүсгэх</b> Шүхрийн буулт үйлдэж байгаа этгээд нь хэрэгцээ шаардлагагүйгээр дараах этгээдэд аюултай нөхцөл байдал үүсгэхгүй байх үүрэгтэй: (1) тухайн шүхэр хаях агаарын хөлөг, эсхүл бүхээгт байгаа хүмүүст; эсхүл (2) бусад шүхэрчид, эсхүл бусад нислэгийн хөдөлгөөнд; эсхүл (3) газарт байгаа хүн, эсхүл өмч хөрөнгөд.</p>	<p><b>105.7. Хохирол учруулах</b> (а) Шүхэрчин хүндэтгэх шалтгаангүйгээр дараах зүйлд саад, хохирол учруулахыг хориглоно:  1/ шүхэрчдийг зөөж буй агаарын хөлөг, агаарын хөлөгт байгаа хүмүүст; 2/ бусад шүхэрчид болон нислэгийн хөдөлгөөнд;  3/ газар дээрх хүн болон өмч хөрөнгөд.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан -“Хохирол учруулах” гэснийг “Аюултай нөхцөл байдал үүсгэх” гэж өөрчдөгдсөн</p>
<p><b>105.9. Агаарын хөлгөөс гарах</b> Дараах этгээд зөвшөөрснөөс бусад тохиолдолд, аливаа этгээд нь шүхрийн буулт үйлдэхээр агаарын хөлгөөс гарч болохгүй: (1) тухайн хөлгийн дарга; эсхүл (2) тухайн зорилгоор хөлгийн даргын томилсон этгээд.</p>	<p><b>105.9. Агаарын хөлгөөс гарах</b> (а) Шүхэрчин нь агаарын хөлгийн дарга, эсхүл агаарын хөлгийн даргын томилсон этгээдээс зохих тушаал, зөвшөөрөл аваагүй тохиолдолд шүхрээр буухаар агаарын хөлгөөс гарахыг хориглоно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p><b>105.11. Шүхэр задлах минимум түвшин</b> (а) Энэ зүйлийн (b) болон (с)-д зааснаас бусад тохиолдолд, шүхрийн буулт үйлдэж байгаа этгээд нь 600 м -ээс (2000 ft) доошгүй өндөрт үндсэн шүхрээ задална. (b) Сурагч-шүхэрчин нь 900 м-ээс (3000 ft) доошгүй өндөрт үндсэн шүхрээ задална. (c) <u>Тандем-мастер</u> нь 1500 м-ээс (5000 ft) доошгүй өндөрт үндсэн шүхрээ задална.</p>	<p><b>105.11. Шүхэр задлах хамгийн бага өндөр</b> (а) Энэ зүйлийн (б), (в)-д зааснаас гадна, шүхэрчин үндсэн шүхрээ 600 м (2000 фут)-ээс доошгүй өндөрт задална.  (б) Сурагч шүхэрчин нь үндсэн шүхрээ 900 м (3000 фут)-ээс доошгүй өндөрт задална. (в) <u>Цувааны ахлагч</u> үндсэн шүхрээ 1500 м (5000фут)-ээс доошгүй өндөрт задална.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан, -“Цувааны ахлагч” гэснийг “тандем мастер” гэж өөрчилсөн</p>
<p><b>105.13. Шүхрийн буулт</b> Дараахаас бусад талбайд, аливаа этгээд нь шүхрийн буулт үйлдэхгүй байх үүрэгтэй: (1) ИНД-71-ийн дагуу С, эсхүл D ангиллын хяналттай агаарын зайд; эсхүл (2) шүхрийн байгууллагаас хүчинтэй нислэгийн зурагт тусгагдсан, эсхүл тухайн шүхрийн ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг AIP-ын нэмэлт хавсралт, эсхүл NOTAM хэлбэрээр зарлан мэдэгдсэнийг үндэслэн, зөвшөөрсөн бүсэд.</p>	<p><b>105.13. Шүхрээр буух <u>бүс</u></b> (а) Шүхэрчин нь:  <u>1/ ИНД-73-аар тодорхойлогдсон шүхрээр буух бүсэд</u>; эсхүл  2/ ИНД-71-д заагдсан С буюу D ангиллын агаарын зайд; эсхүл  3/ AIP-ын нэмэлт буюу NOTAM–аар зарлагдсан, шүхрийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгогдсон бүсэд тус тус бууна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p><b>105.15. Шүхрээр <u>буух</u> талбай</b> (а) Шүхрийн буулт үйлдэж байгаа этгээд нь дараах үүрэгтэй: (1) шүхрийн байгууллагын тогтоосон шүхрээр буух талбайд буух; эсхүл (2) <u>Хууль болон ИНД-115-ын дагуу Даргын олгосон Чөлөөт нисэхийн байгууллагын гэрчилгээний</u></p>	<p><b>105.15. Шүхрээр <u>газардах</u> талбай</b> (а) Шүхэрчин нь эрх бүхий байгууллагаас тодорхойлсон газардах талбайд шүхрээр буулт үйлдэнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан.  -Amend.5-аар өөрчлөгдсөн</p>

<p><a href="#">эрхийн хүрээнд гүйцэтгэж байгаа тандем шүхрийн үйл ажиллагааны хувьд, гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан, Даргын хүлээн зөвшөөрсөн шүхрээр буух талбайд буух.</a></p> <p>(b) Шүхрээр буух талбайг дараах талбайгаас тусад нь тогтоосон <a href="#">аэродромд шүхэр болон агаарын хөлгийн хөдөлгөөнийг зэрэг үйлдэж болно:</a></p> <ol style="list-style-type: none"> <li>(1) ашиглаж байгаа хөдөлгөөнт бүсийн хэсгээс;</li> <li>(2) ашиглаж байгаа ХБЗ-аас;</li> <li>(3) ашиглаж байгаа явгалах замаас;</li> <li>(4) ашиглаж байгаа хэлипорт, ХБЗ-ны ойртолтын болон нисэн гарах бүсээс.</li> </ol> <p>(c) Шүхрээр буух усан талбайд шүхрийн буулт үйлдэж байгаа этгээд нь дараах нөхцөлийг бататгах үүрэгтэй:</p> <ol style="list-style-type: none"> <li>(1) шүхрээр буух талбай нь тодорхой тогтоосон периметртэй байх;</li> <li>(2) бүх шүхэрчдийг татан гаргахад шаардлагатай арга хэмжээ авсан байх.</li> </ol>	<p>(б) Агаарын хөлгийн хөдөлгөөн болон шүхрээр буух үйл ажиллагааг эхлүүлэхдээ шүхрээр газардах аэродромын талбай нь дараах шаардлагыг хангасан эсэхийг бататгана:</p> <ol style="list-style-type: none"> <li>1/ хөдөлгөөн үйлдэгдэж байгаа талбайн аливаа хэсгээс чөлөөтэй байх;</li> <li>2/ ашиглалтанд байгаа хөөрөх буух зурваснаас чөлөөтэй байх;</li> <li>3/ ашиглагдаж байгаа явгалах зурвасны аливаа хэсгээс чөлөөтэй байх;</li> <li>4/ онгоц болон нисдэг тэрэгний хөөрөн гарах, ойртолт үйлдэх талбайн ашиглагдаж байгаа аливаа хэсгээс чөлөөтэй байх.</li> </ol> <p>(в) Шүхрээр усан дээр буух тохиолдолд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1/ шүхэрчний газардах талбайн хязгаар тодорхой тэмдэглэгдсэн; мөн</li> <li>2/ буусан шүхэрчнийг хуурай газар дээр гаргах арга хэмжээг авсан байна.</li> </ol>	<p>-Зэрэг үйлдэж болно гэж тодотгож орсон.</p>
<p><b>105.17. Газрын дохио</b>  <a href="#">Хэрэв шүхрийн буулт үйлдэж байгааг газрын дохио ашиглан үзүүлж байгаа бол</a>, газрын дохио нь салхи руу чиглэсэн конус болон цагаан өнгийн цагиргаас бүрдэнэ.</p>	<p><b>105.17. Газрын дохио тэмдэг</b>  (a) Шүхэрчин газардах талбайгаа сонгоход зориулагдсан, салхины чиглэлээр хөдөлдөг цагаан өнгийн конус хоолойг шүхрээр газардах талбайд байрлуулна.</p>	<p>-Орчуулга найруулга зассан  -Нөхцөлийг зааж өгсөн.</p>
<p><b>105.19. Хяналттай агаарын зай</b>  (a) <a href="#">Орон нутгийн</a> шүхрийн үйл ажиллагаа эрхлэгч болон тухайн агаарын зайг хариуцсан Нислэгийн хөдөлгөөний удирдлагын (НХУ) нэгжийн хооронд гэрээ байгуулснаас бусад тохиолдолд аливаа этгээд нь хяналттай агаарын зайд шүхрийн үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байх үүрэгтэй.</p> <p><a href="#">(b) Дараахаас бусад тохиолдолд аливаа этгээд нь хяналттай агаарын зайд шүхрийн буулт үйлдэхгүй, эсхүл түүнд шүхрээр буулт үйлдэн нэвтрэхгүй байх үүрэгтэй:</a></p> <ol style="list-style-type: none"> <li>(1) <a href="#">тухайн этгээдийг шүхэр хаях агаарын хөлгөөс гарахаас өмнө НХУ-аас шүхрийн буулт үйлдэх зөвшөөрөл олгосон бол;</a></li> <li>(2) тухайн этгээд нь <a href="#">НХУ-ын</a> зөвшөөрлийн дагуу буулт үйлдэх бол.</li> </ol>	<p><b>105.19. Хяналттай агаарын зай</b>  (a) Аливаа этгээд тухайн <a href="#">бус нутгийн</a> нислэгийн хөдөлгөөний удирдлагатай урьдчилан тохиролцоогүй тохиолдолд хяналттай агаарын зайд шүхрийн үйл ажиллагаа явуулж болохгүй.</p> <p>(б) Хяналттай агаарын зайд агаарын хөлгөөс шүхрээр бууж байгаа шүхэрчин:</p> <ol style="list-style-type: none"> <li>1/ нислэгийн хөдөлгөөний удирдагчаас зохих зөвшөөрөл авсан байна,</li> <li>2/ зөвхөн тухайн зөвшөөрлийн хүрээнд шүхрээр буулт үйлдэнэ.</li> </ol>	<p>-Amend.2-оор Шаардлага илүү тодорхой болсон.</p>

<p><b>105.21. Аэродром дээр буулт <u>үйлдэх</u></b>  Аэродром дээр шүхрийн буулт үйлдэх этгээд нь дараах үүрэгтэй:  (1) тухайн аэродромын үйл ажиллагаа эрхлэгчтэй урьдчилан <u>гэрээ</u> байгуулсан байх;  (2) хэрэв Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ (НХУ) байхгүй бол, тухайн аэродром дахь аэродромын хөдөлгөөний хайрцагт үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн хөдөлгөөний замаас зайлсхийх.</p>	<p><b>105.21. Аэродромын <u>бүсэд</u> буух</b>  (а) Аэродромын бүсэд буух шүхэрчин нь:  1/ тухайн аэродромыг эзэмшигчтэй урьдчилан <u>тохиролцсон</u> байна;  2/ хэрэв тухайн аэродромд нислэгийн хөдөлгөөний удирдлага байхгүй бол тус аэродром дээр бусад агаарын хөлгүүдийн үйлдэх нислэгийн замаас чөлөөтэй талбайг шүхрээр буух талбай болгон сонгох шаардлагатай.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p><b>105.23. Цэргийн үйл ажиллагааны болон хязгаарлалттай бүсэд буулт үйлдэх</b>  <u>ИНД-71</u>-ийн дагуу тогтоосон цэргийн үйл ажиллагааны бүс, эсхүл хязгаарлалттай бүсэд, тухайн бүсийг хариуцсан эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд аливаа этгээд нь шүхрийн буулт үйлдэхгүй байх үүрэгтэй.</p>	<p><b>105.23. Цэргийн үйл ажиллагаанд зориулагдсан бүс болон хязгаарлалттай бүсэд <u>шүхрээр</u> буух</b>  (а) Аливаа этгээд <u>ИНД-73</u>-аар тогтоогдсон, цэргийн үйл ажиллагаанд зориулагдсан бүс болон хязгаарлалттай бүсэд шүхрийн үйл ажиллагаа явуулах тохиолдолд тухайн бүсийг хяналтандаа байлгадаг байгууллагаас зөвшөөрөл авсан байх шаардлагатай.</p>	<p>-Орчуулга найруулга зассан  - ИНД-73-г ИНД-71-ээр өөрчлөгдсөн</p>
<p><b>105.25. Үүлнээс зай <u>барих</u></b>  (а) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд, шүхрийн буулт үйлдэж байгаа этгээд нь <u>үүлнээс зайтай байх</u> үүрэгтэй.  (б) Хэрэв тухайн этгээд нь НХУ-аас тухайн үйлдлийг хийх зөвшөөрөл авсан бол, ИНД-71-ийн дагуу С, эсхүл D ангиллын хяналттай агаарын зай гэж тогтоосон агаарын зайд үүл нэвтлэн шүхрийн буулт үйлдэж болно.</p>	<p><b>105.25. Үүлнээс <u>зайлсхийх</u></b>  (а) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд зөвхөн <u>үүлгүй цэлмэг үед</u> шүхрээр бууна.  (б) Аливаа этгээдийг ИНД-71-д заасан, С эсхүл D ангиллын хяналттай агаарын зайд нислэгийн хөдөлгөөний удирдлагаас зохих зөвшөөрөл авсан тохиолдолд үүл нэвтлэн шүхрээр бууж болно</p>	<p>-Орчуулга найруулга зассан  - “үүлгүй цэлмэг үед” гэснийг “үүлнээс зай барих” гэж өөрчлөгдсөн</p>
<p><b>105.27. <u>Өндөр түвшнээс буулт үйлдэх</u></b>  (а) Битүүмжлэлгүй агаарын хөлгөөс шүхрийн буулт үйлдэх этгээд нь:  (1) 3000 - <u>3900 м-ийн</u> (10 000 - 13 000 ft) түвшний хооронд 30 минутаас <u>дээш</u> хугацаагаар <u>нисэх бол</u>, тухайн агаарын хөлгөөс гарах агшин хүртэл нэмэлт хүчилтөрөгч ашиглана;  (2) <u>3900</u> – 6000 м-ийн (13 000 - 20 000 ft) <u>түвшний хооронд</u>, агаарын хөлгөөс гарах агшин хүртэл нэмэлт хүчилтөрөгч ашиглана.  (б) Битүүмжлэлтэй агаарын хөлгөөс шүхрийн буулт үйлдэх этгээд нь <u>3900 – 6000 м-ийн</u> (13 000 - 20 000 ft) түвшний хооронд, <u>даралт бууруулж эхлэх агшнаас</u>, агаарын хөлгөөс гарах агшин хүртэлх бүх хугацаанд нэмэлт хүчилтөрөгч ашиглана.  (с) <u>3900 м</u>-ээс (13 000 ft) дээш <u>түвшнээс</u> шүхрийн буулт үйлдэх этгээд нь шүхрийн байгууллагын зохион</p>	<p><b>105.27. <u>Хэт өндрөөс буух</u></b>  (а) Битүүмжлэлгүй агаарын хөлгөөс шүхрээр буух шүхэрчин нь:  1/ 3000м (10000фут)-ээс <u>4000м</u> (13000 фут)-ийн өндөрт 30 минутаас <u>илүү</u> хугацаанд <u>байх тохиолдолд</u> агаарын хөлгөөс гарах хүртлээ нэмэлт хүчилтөрөгч хэрэглэнэ;  2/ <u>4000м</u> (13000 фут)-ээс 6000м (20000 фут)-ийн <u>өндөрт</u> агаарын хөлгөөс гарах хүртлээ нэмэлт хүчилтөрөгч хэрэглэнэ.  (б) Битүүмжлэлтэй агаарын хөлгөөс шүхрээр буух шүхэрчин нь <u>4000м</u> (13000 фут)-ээс 6000м (20000 фут)-ийн өндөрт <u>битүүмжлэл алдах мөчөөс</u> агаарын хөлгөөс гарах хүртэлх хугацаанд нэмэлт хүчилтөрөгч хэрэглэнэ.  (в) <u>4000 м</u> (130000 фут)-ээс дээш <u>өндрөөс</u> шүхрээр буух шүхэрчин нь эрх бүхий байгууллагаас зохион явуулсан, хэт өндрөөс шүхрээр</p>	<p>-Орчуулга найруулга зассан  -4000м-ийг 3900м болгон нарийвчилсан  -Утгын алдаа зассан.</p>



<p>байгуулсан, өндөр түвшнээс буулт үйлдэх сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байна.</p> <p>(d) 6000 м-ээс (20 000 ft) дээш <u>түвшнээс</u> шүхрийн буулт үйлдэх этгээд нь, <u>даралтыг буулгаж эхлэх агшнаас өмнө</u>, эсхүл агаарын хөлөгт суурилуулсан нэмэлт <u>хүчилтөрөгчийн системээс хэрэглээг салгаснаас эхлэн 3900 м-ээс</u> (13 000 ft) доош түвшин хүртэл өндөр алдах үед хувийн нэмэлт хүчилтөрөгч ашиглана.</p>	<p>буух дадлага сургалтанд амжилттай хамрагдсан байна.</p> <p>(г) 6000 м (20000 фут)-ээс дээш <u>өндрөөс</u> шүхрээр буух шүхэрчин нь агаарын хөлгийн <u>битүүмжлэл алдагдахаас өмнө</u>, эсхүл агаарын хөлөгт суурилуулсан <u>хүчилтөрөгчийн системээс салах мөчөөс эхлэн</u>, буулт <u>4000 м</u> (13000 фут)-ийн өндөрт хүрэх хүртэл нэмэлт тусдаа хүчилтөрөгч хэрэглэнэ.</p>	
<p><b>В Бүлэг - Шүхрийн <u>төхөөрөмж</u></b></p> <p><b>105.51. Шүхэр</b></p> <p>(a) Шүхрийн буулт үйлдэх этгээд, эсхүл тандем хос нь шүхрийн байгууллагын техникийн стандартыг хангасан үндсэн шүхрээр тоноглогдсон байна.</p> <p>(b) Шүхрийн буулт үйлдэх этгээд, эсхүл тандем хос нь дараах нөөц шүхрийн иж бүрдлээр тоноглогдсон байна:</p> <p>(1) шүхрийн байгууллагын техникийн стандартыг хангасан;</p> <p>(2) шүхрийн техникч өмнөх 7 сарын дотор шүхрийн байгууллагын техникийн стандартын дагуу үзлэг шалгалт хийн, дахин баглаж нислэгт тэнцэхээр гэрчилгээжүүлсэн.</p> <p>(c) Тандем шүхрийн буулт үйлдэх тандем зорчигч дараах бэхэлгээ, тоноглолтой байна:</p> <p>(1) шүхрийн байгууллагын техникийн стандартыг хангасан;</p> <p>(2) тандем-мастерын бэхэлгээ тоноглолд таарч, гүйцэд зөв түгжигдсэн.</p>	<p><b>Б БҮЛЭГ. ШҮХРИЙН <u>ТОНОГЛОЛ</u></b></p> <p><b>105.51. Шүхэр</b></p> <p>(a) Ганцаарчилсан болон цувааны хос буулт хийх шүхэрчин нь эрх бүхий байгууллагын техникийн стандартад нийцсэн үндсэн шүхэртэй байна.</p> <p>(б) Ганцаарчилсан болон цувааны хос буулт хийх шүхэрчин нь нөөц шүхэртэй байх ба тэр нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ эрх бүхий байгууллагын техникийн стандартад нийцсэн байх;</p> <p>2/ шүхрийг хэрэглэхээс өмнөх 7 сарын дотор эрх бүхий байгууллагаас баталсан техникийн стандартын дагуу, шүхрийн техникчээр шалгуулж, дахин баглаж, ашиглалтанд тэнцэнэ гэдгийг нь баталгаажуулсан байна.</p> <p>(в) Цувааны дагалдан шүхэрчин нь бэхэлгээ бүстэй байх ба энэ бүс нь:</p> <p>1/ эрх бүхий байгууллагаас баталсан стандартад тохирсон, мөн</p> <p>2/ цувааны ахлагчийн бэхэлгээ бүстэй зохих ёсоор холбогдсон байна.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p> <p>-Шүхрийн “тоноглол “гэснийг “төхөөрөмж” гэж өөрчлөгдсөн</p>
<p><b>105.53. Өндөр <u>хэмжигч</u></b></p> <p>10 секундээс дээш чөлөөт-уналтаар буулт <u>үйлдэх этгээд, эсхүл тандем хос</u> нь:</p> <p>(1) шүхрийн буултад ашиглахад тохиромжтой төрлийн, ажиллагаатай өндөр хэмжигчээр тоноглогдсон байна;</p> <p>(2) шөнө гэрэлтдэг өндөр-хэмжигчээр тоноглогдсон байна;</p> <p>(3) хөөрөхийн өмнө, өндөр-хэмжигчийг шүхрээр буух талбайд тэглэж тохируулна.</p>	<p><b>105.53. Өндрийн <u>хэрэглэл</u></b></p> <p>(a) <u>Ганцаарчилсан шүхэрчин буюу цувааны хос шүхэрчид</u> нь 10 секундээс дээш хугацаагаар чөлөөт уналт хийх тохиолдолд:</p> <p>1/ шүхэрт тохиромжтой өндрийн хэрэглэлээр тоноглогдсон байна;</p> <p>2/ шөнийн цагт гэрэлтдэг өндрийн хэрэглэлээр тоноглогдсон байна;</p> <p>3/ агаарын хөлгөөр хөөрөхөөс өмнө өндрийн хэрэглэлийг шүхрээр буух талбайн хувьд тэг дээр тохируулна.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p><b>105.55. Автомат задлагч <u>төхөөрөмж (АЗТ)</u></b></p> <p>Шүхрийн буулт үйлдэх сурагч-шүхэрчин, эсхүл тандем хос нь дараах АЗТ-тэй нөөц шүхрээр тоноглогдсон байна:</p> <p>(1) 105.111-д шаардсан шүхрийн иж бүрдлийн</p>	<p><b>105.55. Автомат задлагч</b></p> <p>(a) Сурагч, эсхүл цувааны хос шүхэрчний нөөц шүхэр нь дараах шаардлагыг хангасан автомат задлагчаар тоноглогдсон байна:</p> <p>1/ энэ дүрмийн 105.111-д заасны дагуу, шүхрийн тоноглолд</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>

<p>эвхэлтийн бүртгэлд, тухайн шүхрийн иж бүрдэлтэй тохирч байгааг шүхрийн техникч бататгасан;</p> <p>(2) үйлдвэрлэгчийн зааварчилгааны дагуу техник үйлчилгээ болон тохиргоо хийсэн;</p> <p>(3) нөөц шүхрийг шүхрээр буух талбайгаас дээш, дараах минимум өндөрт задлахаар тохируулсан:</p> <p>(i) сурагч-шүхэрчний буултын хувьд, <u>300 м</u> (1000 ft); эсхүл</p> <p>(ii) тандем шүхрийн буултын хувьд, 600 м (2000 ft); эсхүл</p> <p>(iii) тухайн <u>хэрэглээний категорин хувьд</u>, урьдчилан тогтоосон өндөр (АЗТ-ийн үйлдвэрлэгчээс тухайн АЗТ-д тохируулсан болон шүхрээр буух талбайд тэглэсэн);</p> <p>(4) шүхрийн техникч үйлдвэрлэгчийн зааварчилгааны дагуу үзлэг шалгалт хийсэн.</p>	<p>тохирсон эсэхийг шүхрийн бүртгэлийн картан дээр шүхрийн техникч баталгаажуулсан;</p> <p>2/ үйлдвэрлэгчээс гаргасан ашиглалтын зааврын дагуу үзлэг шалгалт, тохируулга хийгдсэн;</p> <p>3/ шүхрээр буух талбайгаас дээш, дор дурьдсан өндөрт шүхэр автоматаар задрахаар тохируулга хийгдсэн:</p> <p>3.1 сурагч шүхэрчний хувьд <u>350</u> м (1000 фут)-ийн өндөрт; эсхүл</p> <p>3.2 цуваа шүхэрчдийн хувьд 600 м (2000 фут)-ийн өндөрт; эсхүл</p> <p>3.3 <u>ашиглалтын төрөлд</u> зориулж үйлдвэрлэгчээс тохируулсан өндөрт.</p> <p>4/ үйлдвэрлэгчээс гаргасан зааврын дагуу шүхрийн техникчээр шалгагдсан байна.</p>	<p>-350м-ийг 300м болгон нарийвчилсан.</p>
<p><b>105.57. Аюулгүй байдлын <u>хамгаалалтын хэрэгсэл</u></b></p> <p>(a)Усанд шүхрийн буулт үйлдэхээр <u>зорьж байгаа этгээд нь толгойгоо усны гадаргуу дээр ил байлгахад тохиромжтой хөвөх хэрэгслийг</u> өмссөн байна.</p> <p>(b)Усны аюултай орчноос <u>1,8 км (1 nm) хүртэлх зайд шүхрийн буулт үйлдэхээр зорьж байгаа сурагч-шүхэрчин</u> нь толгойгоо усны гадаргуу дээр ил байлгахад тохиромжтой хөвөх хэрэгслийг өмссөн байна.</p> <p>(c)Шүхрийн буулт үйлдэх сурагч-шүхэрчин нь шүхрийн байгууллагаас маягийг нь зөвшөөрсөн хамгаалалтын хатуу дуулган малгай өмссөн байна.</p> <p>(d)Шүхрийн буулт үйлдэх <u>тандем хос нь</u> шүхрийн байгууллагаас зөвшөөрсөн хамгаалалтын малгай өмссөн байна.</p>	<p><b>105.57. Аюулгүйн <u>тоног төхөөрөмж</u></b></p> <p>(a) Усан дээр буух тохиолдолд <u>шүхэрчин</u> нь <u>хамгаалалтын хөвөгч хэрэгсэл</u> өмсөж хэрэглэнэ.</p> <p>(б) <u>Сурагч шүхэрчин</u> уснаас <u>2 километрийн</u> зайд шүхрээр буухаар тооцоолсон тохиолдолд хамгаалалтын хөвөгч хэрэгсэл заавал өмсөж хэрэглэнэ.</p> <p>(в) Сурагч шүхэрчин нь эрх бүхий байгууллагаар зөвшөөрөгдсөн хамгаалалтын хатуу дуулга малгай хэрэглэнэ.</p> <p>(г) <u>Цувааны хос</u> шүхэрчин нь эрх бүхий байгууллагаар зөвшөөрөгдсөн хамгаалалтын дуулга малгай өмсөнө.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p> <p>-2 км-ийг 1,8 болгон нарийвчилсан.</p> <p>-Цувааны хос нь тандем хос болсон</p>
<p><b>С Бүлэг - Шүхрийн <u>техник</u> үйлчилгээ</b></p> <p><b>105.101. Шүхрийн техникч</b></p> <p>Шүхрийн техникч нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:</p> <p>(1)18 нас хүрсэн байх;</p> <p>(2)шүхрийн байгууллагаас олгосон шүхрийн техникчийн үнэмлэх эзэмшдэг байх;</p> <p>(3)тухайн үнэмлэхний эрх, хязгаарлалтыг мөрдөх;</p> <p>(4)тухайн шүхрийн байгууллагын үйл ажиллагааны</p>	<p><b>В БҮЛЭГ. ШҮХРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ</b></p> <p><b>105.101. Шүхрийн техникч</b></p> <p>(a) Шүхрийн техникчид дараах шаардлага тавигдана:</p> <p>1/ 18 нас хүрсэн;</p> <p>2/ эрх бүхий байгууллагаас олгогдсон шүхрийн техникчийн гэрчилгээтэй байх;</p> <p>3/ гэрчилгээнд заагдсан эрх, хязгаарлалтуудын хүрээнд, эрх бүхий байгууллагаас баталсан стандарт журмыг баримталж ажиллах үүрэгтэй.</p>	

<p>стандарт болон журмыг мөрдөх; эсхүл  <u>(5)Хууль болон ИНД-115-ын дагуу Даргын олгосон Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа тандем шүхрийн хувьд, шүхрийн техникч нь ИНД-115.61-ийн дагуу батлагдсан техник үйлчилгээний хөтөлбөрийн хүрээнд тухайн тандем шүхрийн техник үйлчилгээг хийх.</u></p>		<p>-Amend.5 -аар нэмэгдсэн</p>
<p><b>105.103. НТЧ-ын болон <u>аюулгүй байдлын удирдамж</u></b>  Шүхрийн иж бүрдэл нь дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь шүхрийн буулт үйлдэхгүй байх үүрэгтэй:  (1) ИНД-39-ийн дагуу болон <u>Даргын</u> гаргасан хамааралтай НТЧ-ын удирдамж;  (2) шүхрийн байгууллагаас гаргасан <u>хамааралтай аюулгүй байдлын удирдамж</u>;  <u>(3) дараахаас бусад тохиолдолд, үйлдвэрлэгчийн гаргасан хамааралтай, заавал хэрэгжүүлэх модификаци, эсхүл зааварчилгаа:</u>  <u>(i) тухайн модификаци, эсхүл зааварчилгааг шүхрийн байгууллагаас гаргасан аюулгүй байдлын удирдамжид заасан байх; эсхүл</u>  <u>(ii) тухайн модификаци, эсхүл зааварчилгаанд оруулсан засварыг шүхрийн байгууллага зөвшөөрсөн байх.</u></p>	<p><b>105.103. Нислэгт тэнцэх чадварын болон <u>Аюулгүй ажиллагааны удирдамж</u></b>  (а) Дараах шаардлагыг хангаагүй шүхрийг ашиглахыг хориглоно.   1/ <u>ИНЕГ</u>-аас гаргасан холбогдох Нислэгт тэнцэх чадварын удирдамжийг биелүүлсэн; ба  2/ эрх бүхий байгууллагаас гаргасан Аюулгүй ажиллагааны удирдамжийг биелүүлсэн; ба  3/ үйлдвэрлэгчээс гаргасан зааварчилгаа, нэмэлт өөрчлөлтийг гүйцэтгэсэн.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан   -“ИНЕГ “ гэснийг “Дарга” гэж өөрчлөгдсөн   -Amend.3-аар нэмэгдсэн</p>
<p><b>105.105. Шүхрийн <u>ажиллагаатай байдал</u></b>  (а)Шүхрийн иж бүрдлийг ажиллагаагүй, эсхүл нислэгт тэнцэхгүй болохыг тогтоосон этгээд нь тухайн иж бүрдэл ажиллагаагүй гэдгийг тодорхой тэмдэглэж, бататгах үүрэгтэй.  (б)Аливаа этгээд нь, ажиллагаагүй гэж тэмдэглэсэн шүхрийн иж бүрдлийг, дахин үзлэг шалгалт хийж, ажиллагаатай байдлыг сэргээх болон нислэгт тэнцэх байдалд оруулах хүртэл ашиглалтад шилжүүлэхгүй.</p>	<p><b>105.105. Шүхрийн <u>ашиглалт</u></b>  (а) Ашиглалтын шаардлага хангаагүй, ашиглалтанд тэнцэхгүй нь тогтоогдсон шүхэрт “Ашиглахыг хориглоно” гэсэн тэмдэглэгээг заавал хийнэ.   (б) Ашиглахыг хориглосон тэмдэгтэй шүхрийг дахин шалгаж “шаардлага хангасан”, “ашиглалтанд зөвшөөрнө” гэсэн тэмдэглэгээ хийгдэхээс нааш ашиглаж болохгүй.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p><b>105.107. <u>Модификаци болон засвар</u></b>  Шүхрийн иж бүрдлийн <u>НТЧ-т нөлөөлж болох хэлбэрээр</u> өөрчлөлт, эсхүл засвар хийсэн эсхүл бэхэлгээ тоноглол болон сав, баглааны системийг, шүхрийн техникч шүхрийн байгууллагаас баталсан техникийн стандартын дагуу <u>дахин</u> үзлэг шалгалт болон <u>үнэлгээ</u> хийж гүйцэтгэснээс бусад тохиолдолд аливаа этгээд тухайн шүхрийг</p>	<p><b>105.107. Засвар, <u>шинэчлэлт</u></b>  (а) Шүхэр, эсхүл бэхэлгээ болон шүхрийн сав, баглааны системийн аюулгүй ажиллагаанд нөлөөлж болох хэсэгт засвар, эсхүл өөрчлөлт шинэчлэлт хийсний дараа уг хэсэгт үзлэг хийж, эрх бүхий байгууллагаас баталсан техникийн стандартад тохирсон гэсэн дүгнэлт гаргах хүртэл уг шүхрийг ашиглахыг хориглоно.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>

<p>ашиглахгүй.</p> <p><b>105.109. Шүхрийн иж бүрдлийг <u>шалгах</u></b></p> <p>(а) Энэ зүйлийн (b) болон (c)-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд шүхрийн иж бүрдлийн ажиллагаатай байдлыг дараах хэлбэрээр шалгаагүй бол шүхрийн буулт үйлдэхгүй:</p> <p>(1) шүхрийн иж бүрдлийн эвхэлтийн бүртгэлийн ишлэлийг шалгах;</p> <p>(2) өргөн хүрээтэй гадна үзлэг хийх;</p> <p>(3) бүх төхөөрөмжийг зохих ёсоор ажиллахаар тохируулсныг шалгах;</p> <p>(4) шүхрийн иж бүрдлийн зохистой ажиллагаанд нөлөөлөх эд зүйл авч яваагүй болохыг бататгах.</p> <p>(b) Сурагч-шүхэрчний хувьд, шүхрийн байгууллагаас тухайн сурагчийн буултад шууд хяналт тавихаар зөвшөөрөгдсөн этгээд нь энэ зүйлийн (а)-д заасны дагуу тухайн сурагчийн хэрэглэж байгаа төхөөрөмжид үзлэг хийнэ.</p> <p>(c) Тандем зорчигчийн хувьд, тандем-мастер нь энэ зүйлийн (а)-д заасны дагуу тухайн тандем зорчигчийн хэрэглэж байгаа төхөөрөмжид үзлэг хийнэ.</p>	<p><b>105.109. Шүхрийн иж бүрдлийн <u>үзлэг</u></b></p> <p>(а) Энэ зүйлийн (б), (в)-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд шүхрийн иж бүрдлийг дараах байдлаар шалгаагүй бол уг шүхрийг ашиглахыг хориглоно:</p> <p>1/ шүхрийн эвхэлтийг, шүхрийн бүртгэлийн картын хамт шалгах;</p> <p>2/ иж бүрдлийн гадаад байдлыг нягтлан шалгах;</p> <p>3/ бүх тоноглолууд зохих ёсоор тохируулагдсан, ажиллагаанд бэлэн эсэх;</p> <p>4/ шүхрийн ажиллагаанд саад болох эд зүйлс байгаа эсэх.</p> <p>(б) Сурагч шүхэрчний хувьд, түүний шүхрийн иж бүрдлийг эрх бүхий байгууллагаас томилогдсон этгээд энэ зүйлийн (а)-д заасны дагуу шалгана.</p> <p>(в) Цувааны дагалдан шүхэрчний хувьд, түүний шүхрийн иж бүрдлийг энэ зүйлийн (а)-д заасны дагуу цувааны ахлагч шалгана.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p><b>105.111. Шүхрийн бүртгэл <u>хөтлөх</u></b></p> <p>(а) Ослын, эсхүл нөөц шүхрийн <u>иж бүрдлийн өмчлөгч нь</u> иж бүрдлийн ажиллагаатай байдлын тухайн үеийн төлөв байдлыг тэмдэглэсэн, иж бүрдлийн эвхэлтийн бүртгэлийн карт хөтлөх үүрэгтэй. Эвхэлтийн бүртгэл нь тухайн шүхрийн иж бүрдэлтэй байнга хамт байх ёстой.</p> <p>(b) Хууль болон ИНД-115-ын дагуу Даргын олгосон Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлдэггүй сурагч-шүхэрчний шүхрийн иж бүрдэл, эсхүл тандем шүхрийн иж бүрдлийн өмчлөгч нь шүхрийн байгууллагын зөвшөөрсөн форматаар тухайн иж бүрдлийн байнгын бүртгэлийг хөтлөх үүрэгтэй.</p> <p><u>(c) Хууль болон ИНД-115-ын дагуу Даргын олгосон Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа тандем шүхрийн иж бүрдэл эзэмшигч нь тухайн иж бүрдлийн бүртгэлийг ИНД-115.67-гийн шаардлагын дагуу хөтлөх үүрэгтэй.</u></p>	<p><b>105.111. Шүхрийн бүртгэл</b></p> <p>(а) <u>Аваарын</u> буюу нөөц шүхэр эзэмшигч нь шүхрийн ажиллагаа, ашиглалтын бүртгэл хөтлөх бөгөөд бүртгэлийн картыг шүхрийн иж бүрдэлд байнга хадгална.</p> <p>(б) Сурагч шүхэрчинд зориулагдсан шүхэр, эсхүл цуваанд зориулагдсан шүхэр эзэмшигч нь эрх бүхий байгууллагаас баталсан маягтын дагуу шүхрийн бүртгэлийн картыг хөтөлнө.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан.</p> <p>-Аваарын – ослын болсон.</p> <p>- Amend.5-аар нэмэгдсэн</p>



(d) Ослын, эсхүл нөөц шүхрийн иж бүрдлийн өмчлөгч, эсхүл ашиглагч болон энэ зүйлийн (b)-д дурдсан шүхрийн иж бүрдлийн өмчлөгч нь Дарга шаардсан үед, эсхүл тухайн шүхрийн байгууллагын журамд заасны дагуу бүртгэлийг шалгуулахад бэлэн байлгах үүрэгтэй.

(в) Аваарын буюу нөөц шүхэр эзэмшигч, эсхүл ашиглагч, мөн энэ зүйлийн (б)-д заагдсан шүхэр эзэмшигч нь ИНЕГ, эсхүл эрх бүхий байгууллагаас шаардсаны дагуу үзлэг хийхэд боломжтой хэлбэрээр бүртгэлийг хөтөлсөн байна

Дүрмийн боловсруулалтын хэлтэс